



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2019 оны II сарын 23 өдөр

Дугаар 107

Дархан

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот
үйлдвэрийн газар байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Дархан-Уул аймгийн орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх, иргэдийн амьдрах орчин нөхцөлийг дээшлүүлэх, хот суурины дахин төлөвлөлтийг хэрэгжүүлэх, гэр хорооллын дэд бүтцийн ашиглалтыг сайжруулах чиг үүрэг бүхий "Дархан дахин төлөвлөлт" Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрыг байгуулсугай.

2. "Дархан дахин төлөвлөлт" Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын дүрмийг боловсруулж, батлуулахыг аймгийн Засаг дарга /С.Насанбат/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЭРДЭНЭБАТ

